



ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2020 оны 08 сарын 11 өдөр

Дугаар А/176


Улаанбаатар хот

Журам батлах тухай

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.4-т заасныг үндэслэн ТУШААХ нь:

1. "Сэтгэл зүй, сэтгэл заслын тусламж үйлчилгээ үзүүлэх журам"-ыг хавсралтаар баталсугай.
2. "Сэтгэл зүй, сэтгэл заслын тусламж үйлчилгээ үзүүлэх журам"-ыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон хэрэгжүүлж, ажиллахыг Төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллагын дарга, захирагч нарт үүрэг болгосугай.
3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг дэд дарга (хурандаа Б.Ууганбаяр)-д даалгасугай.

ДАРГА,
БРИГАДЫН ГЕНЕРАЛ



Г.АРИУНБУЯН

00001923

СЭТГЭЛ ЗҮЙ, СЭТГЭЛ ЗАСЛЫН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Онцгой байдлын байгууллагын алба хаагч, сонсогчдод гамшгийн өмнөх, гамшгийн үе, гамшгийн дараах үед болон гамшигт нэрвэгдэгсдэд сэтгэл зүй, сэтгэл заслын тусламж үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг энэхүү журмаар зохицуулна.

1.2. Журмын зорилго нь онцгой байдлын байгууллагын алба хаагчид гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд оролцох сэтгэл зүйн бэлэн байдлыг хангах, гамшгийн үед иргэдэд сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх, өөрийн сэтгэл зүйн байдлыг удирдах, гамшгийн дараа сэтгэл зүйн тогтвортой байдлыг хангах, сэтгэл зүйн хямралыг зохицуулах, сэтгэцийн тулгамдсан асуудал болон эмгэг үүсэхээс урьдчилан сэргийлж, сэтгэл зүй, сэтгэл заслын тусламж үйлчилгээ үзүүлэх, сэтгэцийн эрүүл мэндийг хамгаалах, хүний нөөцийн тогтвортой байдлыг хангахад оршино.

Хоёр. Сэтгэл зүй, сэтгэл заслын тусламж үйлчилгээ үзүүлэх зохион байгуулалт

2.1. Онцгой байдлын байгууллагын алба хаагчид гамшгийн өмнөх үед сэтгэл зүйн бэлэн байдлыг хангах, тусламж дэмжлэгийг заавар хөтөлбөрийн дагуу зохион байгуулна;

2.2. Гамшгийн үед алба хаагчид өөрийн сэтгэл зүйн байдлыг удирдах, иргэдэд сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, нутгийн захиргааны байгууллага, дотоодын болон олон улсын хүмүүнлэгийн байгууллагуудтай хамтран зохион байгуулна;

2.3. Гамшгийн дараах үед алба хаагчид сэтгэл зүйн тогтвортой байдлаа хадгалж, сэтгэцийн тулгамдсан асуудал, сэтгэцийн эмгэг үүсэхээс урьдчилан сэргийлэх, сэтгэл зүй, сэтгэл заслын тусламж үйлчилгээ үзүүлэх, сэтгэцийн эрүүл мэндийг хамгаалах үйл ажиллагааг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь нутгийн захиргааны байгууллагатай хамтран зохион байгуулна.

Гурав. Сэтгэл зүй, сэтгэл заслын тусламж үйлчилгээ үзүүлэх шаардлага

3.1. Гамшгийн өмнөх үед сэтгэл зүйн бэлэн байдлыг хангах үйл ажиллагаанд онцгой байдлын сургуулийн түвшинд сургалтын үйл ажиллагаагаар, онцгой байдлын байгууллагын түвшинд мэргэжлийн сэтгэл зүйч дэмжлэг үзүүлнэ;

3.2. Гамшгийн болон гамшгийн дараах үед мэргэжлийн сэтгэл зүйч, сэтгэцийн эмч нар сэтгэл зүй, сэтгэл заслын тусламж үйлчилгээг үзүүлнэ;

3.3. Сэтгэл зүйн тусламж үйлчилгээг ганцаарчилсан болон бүлгийн хэлбэрээр зохион байгуулах бөгөөд тусгайлан тохижуулсан өрөө, олон улсын стандартад нийцсэн оношилгооны тест, аргачлал, багаж тоног төхөөрөмж ашиглана.

3.4. Дотоод хэргийн сургууль, Үндэсний аврах бригадын дэргэд сэтгэл зүйн бэлэн байдлыг хангахад чиглэсэн нүүр тулгарах боломж бүхий дуураймал орчныг бүрдүүлэх

Дөрөв. Сэтгэл зүй, сэтгэл заслын тусламж үйлчилгээ үзүүлэхэд баримтлах зарчим

4.1. Мэргэжлийн тусламж үйлчилгээ үзүүлэхэд дараах зарчмыг баримтална. Үүнд:

4.1.1. тусламж үйлчилгээ үзүүлэхдээ хувь хүний нэр төрийг хүндэтгэн үзэх;

4.1.2. мэргэжлийн үйл ажиллагааны хүрээнд олж авсан хувь хүний нууцтай холбоотой мэдээллийг задруулахгүй байх;

4.1.3. үнэнч шударга байдлыг эрхэмлэж, алба хаагчдад ялгавартай хандахгүй байх;

4.1.4. төрийн албаны тухай хууль, цэргийн дүрэм, байгууллагын дотоод журам, төрийн болон албаны нууцын тухай хууль, мэргэжлийн ёс зүйг мөрдөх.

Тав. Сэтгэл зүй, сэтгэл заслын тусламж үйлчилгээний хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаа

Сэтгэл зүй, сэтгэл заслын тусламж үйлчилгээг гамшгийн өмнөх, гамшгийн үе, гамшгийн дараах үед сонсогч, алба хаагч болон иргэдэд чиглэн зохион байгуулна.

5.1. Гамшгийн өмнөх үед дараах арга хэмжээг авна. Үүнд:

5.1.1. Дотоод хэргийн сургуулийн Онцгой байдлын сургуульд элссэн шинэ сонсогч, онцгой байдлын байгууллагад орох хүсэлт гаргасан иргэний сэтгэл зүй, сэтгэцийн байдлыг тодорхойлж, оношлох;

5.1.1.1. онцгой байдлын сургуулийн сонсогчийн сэтгэл зүйн бэлэн байдлыг хангах, дэмжих үйл ажиллагааг цэргийн сургалт бэлтгэлтэй хослуулан зохион байгуулах;

5.1.1.2. онцгой байдлын байгууллагад ажилд орохоор хүсэлт гаргасан иргэнээс мэргэжлийн тодорхойлолтын дагуу багц сорил авч, сэтгэл зүйн дүгнэлт гаргах, шаардлагатай тохиолдолд сэтгэцийн эмчийн үзлэгт хамруулах;

5.1.2. Шинээр орох алба хаагчид албаны онцлогийн талаар мэдлэг, дадлага, бэлтгэл олгоход чиглэсэн ажил зохион байгуулах. Үүнд:

5.1.2.1. онцгой байдлын албанд шинээр томилогдсон, шилжиж ирсэн алба хаагчдад ажилдаа дасан зохицоход нь дэмжлэг үзүүлэх зорилгоор сургалт хийж таниулах үйл ажиллагааг зохион байгуулах;

5.1.3. онцгой байдлын алба хаагчдын сэтгэл зүйн байдлыг судлан, оношлох, судалгаа хийх;

5.1.3.1. алба хаагчийн сэтгэл зүйн хувийн онцлог, сэтгэцийн эрүүл мэндийн байдал, стрессийн түвшин, харилцаа хандлага, багаар ажиллах чадварыг үнэлж дүгнэх зорилгоор сэтгэл зүйн судалгаа хийх;

5.1.3.2. алба хаагч, хамт олны уур амьсгал, ажлын байрны сэтгэл ханамж, ажлын байрны стресс, ажлаас халшрах хам шинж зэрэг асуудлын хүрээнд судалгаа хийх;

5.1.3.3. алба хаагчдын сэтгэл зүйн бэлэн байдлыг тандах зорилгоор айдас, түгшүүр, эрсдэлийг үнэлэх, судалгаа хийх;

5.1.4. Онцгой байдлын алба хаагчид зориулсан сэтгэл зүйн сургалт зохион байгуулах;

5.1.4.1. сэтгэл зүй, сэтгэцийн эрүүл мэндийн тулгамдсан асуудал, сэтгэцийн эмгэгээс урьдчилан сэргийлэх сургалтын хөтөлбөр боловсруулах;

5.1.4.2. бүлгийн дарга нарт удирдахуйн сэтгэл зүйн мэдлэг олгох сургалт зохион байгуулах;

5.1.4.3. батлагдсан сургалтын хөтөлбөрөөр алба хаагчдын сэтгэл зүйн бэлэн байдлыг хангах, бие хүнийг хөгжүүлэх, сэтгэл зүйн мэдлэгийг дээшлүүлэх, олж авсан мэдлэгээ ажил амьдралдаа хэрэгжүүлэхэд чиглэсэн сургалт, практик дадлага бүхий чадавхжуулах арга хэмжээг зохион байгуулах;

5.1.4.4. алба хаагчдын ар гэрт чиглэсэн онцгой байдлын албаны үйл ажиллагааг таниулах, сэтгэл зүйг дэмжих үйл ажиллагааг зохион байгуулах;

5.1.5. Бүлгээр сэтгэл зүй, сэтгэл заслын тусламж үйлчилгээ үзүүлэх. Үүнд:

5.1.5.1. гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд оролцоход багаар ажиллах чадварыг хөгжүүлэх зорилготой сэтгэл зүй, сэтгэл заслын арга техникүүдийг ашиглан дэмжлэг үзүүлэх;

5.1.5.2. гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд оролцсоны дараагаар алба хаагчдад бүлгийн сэтгэл засал эмчилгээний арга техникүүдийг ашиглан сэтгэл зүй, сэтгэл заслын тусламж үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг тогтмол явуулах;

5.1.5.3. алба хаагчид стресс менежмент, ажлын байрны стресс, халшрах хам шинж, айдас түгшүүрийн менежмент, нойргүйдэл гэх мэт сэдвүүдээр танин мэдэхүйн сургалтын хэлбэрээр мэдлэг мэдээлэл олгох;

5.1.6. Ганцаарчилсан сэтгэл зүйн зөвлөгөө, сэтгэл заслын тусламж үйлчилгээ үзүүлэх;

5.1.6.1. алба хаагч өөрийн хүсэлтээр шаардлагатай тохиолдол бүрд тусламж үйлчилгээнд хандах;

5.1.7. гамшгийн өмнөх үед ард иргэдийн сэтгэл зүйн бэлэн байдлыг хангах, гамшгаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах;

5.1.7.1. гамшгийн талаарх мэдээлэл, ойлголтыг зонхилон тохиолддог гамшгийн төрөл бүрээр ард иргэдэд ойлголт өгөх үйл ажиллагааг зохион байгуулах;

5.1.7.2. гамшгийн үед ард иргэдэд үүсэж болзошгүй сэтгэл зүйн хариу урвал, түгшүүрийн үеийн сэтгэл зүй, даган дуурайх нийгмийн сэтгэл зүйн хариу урвал зэрэг сэдвийн хүрээнд ард иргэдэд мэдлэг, мэдээлэл олгох үйл ажиллагааг зохион байгуулах.

Дээрх 5.1 дэх заалтуудыг хэрэгжлүүлэхэд төлөвлөгөөт болон байгууллагын захиалгаар онцгой байдлын анги, салбарын сэтгэл зүйч, сэтгэцийн эмч нар хамтран зохион байгуулах бөгөөд судалгааны үр дүнг тухайн анги, байгууллагын удирдлага, ОБЕГ-ын Эрүүл мэнд, сэтгэл зүйн тасагт танилцуулах;

5.2. Гамшгийн үед дараах арга хэмжээг авна. Үүнд:

5.2.1. Гамшгийн үед нөхцөл байдлын улмаас цочролд орсон алба хаагчид, мэргэжлийн анги, сайн дурын хэсгийнхэнд сэтгэлийн хямрал цочролоос гарах, сэтгэл зүйн байдлыг тогтворжуулахын тулд сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх, багаар хамтран ажиллахад мэргэжил арга зүйгээр удирдан, алба хаагчдад шаардлагатай сэтгэл заслын арга техникийг зааж сургах;

5.2.2. Гамшгийн үед сэтгэл санаа нь хүчтэй цочирсон, тайван бус сэтгэл зүйн тогтворгүй байдалтай нэрвэгдэгсдэд тухайн газарт нь онцгой байдлын байгууллагын алба хаагч, мэргэжлийн анги, сайн дурын хэсгийнхэн сэтгэл зүйн байдлыг тогтворжуулах, тайвшруулах зорилгоор сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх арга техникийг зааж сургах;

5.2.3. Гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд оролцож буй алба хаагч суралцсан мэдлэг, туршлагадаа үндэслэн өөрийн болон баг хамт олонд, мөн нэрвэгдэгсдэд сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх үүргийг хүлээнэ.

5.3. Гамшгийн дараах үед авч хэрэгжүүлэх арга хэмжээг анги, салбарын сэтгэл зүйч, сэтгэцийн эмч нар хамтран зохион байгуулна.

5.3.1. Бүлгээр сэтгэл зүй, сэтгэл заслын тусламж үйлчилгээ үзүүлэх. Үүнд:

5.3.1.1. гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд оролцсоны дараа алба хаагчдад бүлгийн сэтгэл засал эмчилгээг мэдрэмж тайлах, харилцан нөлөөлөх бүлгийн ярилцлага гэх мэт төрлөөр тогтмол хийх;

5.3.1.2. алба хаагчид стресс менежмент, ажлын байрны стресс, халшрах хам шинж, айдас түгшүүрийн менежмент, нойргүйдэл гэх мэт сэдвүүдээр танин мэдэхүйн сургалтын хэлбэрээр мэдлэг мэдээлэл олгох;

5.3.2. ганцаарчилсан сэтгэл зүйн зөвлөгөө, сэтгэл заслын тусламж үйлчилгээ үзүүлэх;

5.3.2.2. гамшгаас хамгаалах үйл ажиллагааны дараа алба хаагчид зайлшгүй хэвтэн эмчлүүлэх шаардлага бүхий сэтгэцийн эмгэг илэрвэл мэргэжлийн байгууллагад хандан тусламж үзүүлэх;

5.3.3. Онцгой байдлын алба хаагчдын сэтгэл зүйн байдлыг судлан, оношлох, судалгаа хийх;

5.3.3.1. гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд оролцсоны дараа алба хаагчдын сэтгэл зүйн байдлыг тандах, үнэлэх судалгааг хийх;

5.3.3.2. алба хаагчдад сэтгэл зүйн хэрэгцээ шаардлагын талаар судалгаа хийх;

5.3.3.3. судалгааны үр дүнг үндэслэн сэтгэлзүйн дэмжлэг үзүүлэх, гарын авлага, зөвлөмж, тараах материалыг боловсруулж ажиллах;

5.3.4. Онцгой байдлын алба хаагчдын хэрэгцээ шаардлагад үндэслэн сэтгэл зүйн сургалт зохион байгуулах;

5.3.5. мэргэжлийн тусламж үйлчилгээний онцлог, тулгарч буй асуудлаар санал зөвлөмж боловсруулах;

5.3.5.1. 5.3.3.1-д үндэслэн санал зөвлөмж боловсруулж тухай бүрд онцгой байдлын байгууллагын удирдлага, ОБЕГ-ын эрүүл мэнд сэтгэл зүйн тасагт танилцуулах;

5.3.5.2. мэргэжлийн тусламж үйлчилгээний явцад гарсан санал, зөвлөмжийн дагуу шаардлагатай арга хэмжээг авахыг удирдлагад уламжлах, байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгах;

5.3.6. Бусад

Онцгой байдлын анги салбарын сэтгэл зүйч, сэтгэцийн эмч нар нь дараах үйл ажиллагааг зохион байгуулах үүргийг хүлээнэ;

5.3.6.1. сахилга, ёс зүйн харилцааны зөрчил, дутагдал гаргасан алба хаагчидтай ажиллах арга хэлбэрийг тодорхойлж, тохирох хөтөлбөрийг боловсруулж, зөрчлийг дахин давтан гаргуулахгүй байх, бууруулахад мэргэжлийн зүгээс туслалцаа үзүүлэх, хамтарч ажиллах;

5.3.6.2. гэр бүл, хувийн асуудал, харилцаанаас үүдэн ажил үүргээ хэвийн гүйцэтгэж чадахгүй байгаа алба хаагчид сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх.

6. Бусад

6.1. Энэ журмын хэрэгжилтэд онцгой байдлын анги салбарын удирдлага, ОБЕГ-ын Гамшгийн шуурхай удирдлагын газар хяналт тавина;

6.2. Онцгой байдлын байгууллагын сэтгэл зүйч, сэтгэцийн эмч, холбогдох албан тушаалтан мэргэжлийн үйл ажиллагааны явцад олж авсан мэдээллийг урвуугаар ашиглан, ёс зүйн зөрчил гаргавал холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

---oOo---